

Хvvхдийг хvчтэй сэгсэрснээс болж ямар гэмтэл vвсдэгийг Та мэдэх vv?

Сvvлийн жилvvдэд бага насны насны хvvхдэд тохиолддог шинэ гэмтэл олж нээгээд байгаа. Уг хам шинж нь хvvхдэдээ уурлаж уцаарласан эцэг эхчvvд нь тvvнийг хvчтэй сэгсэнснээс vвсдэг. Зарим эцэг эхчvvд хvvхдийг сэгсрэхэд яах ч vгvй гэж боддог. Гэвч vвний vр дагавар нь тэдний тосоолж буйгаас илvv хоноолтэй байж мэднэ.

Яагаад уг гэмтэл vвсдэг вэ?

Бага насны, ялангуяа 5-с доош насны хvvхдийг хvчтэй сэгсэрснээс тархинд нь гэмтэл vвсч цус харваж болзошгvй юм. Учир нь Нярай хvvхдийн толгой биенээсээ хvнд, хvзvvний булчин сул тул сэгсрэх вед илvv их бэртэж гэмтэнэ. Нярай, бага насны хvvхдийн тархи жижиг, зоолон, гавлын ясыг дvvргэдэггvй тул сэгсрэх вед тархи нь гавал ясыг моргож цохидог. Мон бага насны хvvхдэд тархины мэдрэлийн судлууд нь гадуураа миелинээр бvрхэгдээгvй байдаг тул хvчтэй сэгсрэх вед их гэмтдэг. Тархины усжилт хvvхдийг хvчтэй сэгсэрснээс тархинд цус харвах, мэнэнгээр хvндрэх боломжтой байдаг гэж эмч нар vздэг.

Эцэг эхчvvд, хvvхэд асрамжлагчид:

Нярай хvvхдийн уйлж буй шалтгааныг мэддэггvйгээс

Хvvхдийг аргадаж тайвшруулах арга мэдэхгvй, уурлаж уцаарласнаас

Оорсдоо сэтгэл санааны дарамттай тул уйлж буй хvvхдээс тvэгшээснээс хvvхдээ сэгсчдэг.

Yр дагавар:

Тархинд цус харвах

Нvдний торлог бvрхэвчинд цус харвах

Нунасны гэмтэл/ саажилт

Татаж унадаг болох

Сохрох

Ясны бэртэл

Хэл яриа болон анхаарал товлорvvлэх хvндрэлтэй болох

Анхаар:

Тухайн одор таны хувьд хvнд хэцvv одор байсан ч

Та их ядарсан ч

Шоно орой хvvхэд чинь уйлж байсан ч

Хvvхэд чинь холоо идэхгvй ч

Бvх зvйлс бvтэлгvй мэт байсан ч

Санагтун:

Бага насны хvvхдийг дээшээ шидэж тоглох

Хvvхдээ морон дээрээ суулгаад давхиж тоглох нь аюултай

5-с доош насны хvvхдийг хэдийд ч сэгсэрч болохгvй

Нярай хvvхдийг тэврэхдээ, тvvнтэй тоглохдоо vргэлж толгойг нь тvшиж бай

Хvvхдийг чинь асарч, хардаг хvн бvрт: уг хам шинжийн тухай ярьж, хvvхдийг **СЭГСРЭХ АЮУЛТАЙ** гэдгийг ойлгуул.

ХҮҮХЭД УЙЛААД БАЙВАЛ:

Хvvхдэд ямар нэгэн

Хэрэгцээ, зовиур байгаа эсэхийг шалгаж тусал

Хvvхдэд угж, хохийг нь ог.

Хvvхдийг тэвэрч бvvвэйл.

Хvvхдэд дуу дуулж, намуун ая тавьж ог.

Салхинд гарга.

Хvvхдээ тэргэнд хэвтvvлж зоолон ходолго.

Хvvхдийг оронд нь хэвтvvлээд оороо оор ороонд орж, тайвшрахын тулд 1 удаа гvн амьсгал.

Нvдээ аниад, хэдхэн минут ходолгоонгvй тайван суухыг хичээ.

Найз ноход, хамаатан садан, хоршоо дуудаад оороо тvр зуур амрахыг бод.